

Үгийн сангаа өвлөө

Бүрэнтөгс (Өвөр Монгол)

Монгол улсын их эрдэмтэн Б. Ринчен мянга есөн зуун тавьдугаар онд монгол улсын "Шинжлэх ухаан" сэтгүүлд нийтэлсэн "Үгийн утга учир" гэдэг өгүүлэлдээ "бид цөм монгол үгээр хэлэлцдэг. Тэгэхдээ бид хэлээ мэддэг гэж хэлэлцдэг, боддог шүү дээ. Гэтэл бид, өөрийнхөө хэлний чухам хичнээн үг мэддэг бол гэж өөртөө асуулт тавьж болно. Энэ асуулт бол дэмий шалиг асуулт биш, бид өөрийнхөө хэлийг аль хэр мэддэг буй. Манай мэдлэг сонирхлын хүрээ аль хэр өргөн байна. Бидний уншсан мэдсэний дэлгэр хомс нь аль хэр байна гэдгийг магадлаж мэдэхэд хэрэгтэй сонин асуулт гэж үзэлтэй" гэж дурдаж билээ. Энэ бол Б. Ринчен гуай одоогоос тавиад жилийн өмнө монгол хэлний бүртгэл судалгааны асуудлыг дурдсан хэрэг болно. Мөн ч монгол хэлний үгийн сан балран хорогдох аюулд учирч юу магад хэмээн гадарлаж залуу үеийнхэнд сануулан сэрэмжлүүлж байсан явдал болно.

Хагас зууны дараах өнөөдөр, бид хэдийвээр монгол хэлний үгийн сангаа компьютерээр бүртгэж эхэлсэн боловч монгол хэлний үгийн сангийн бүртгэл судалгаа арай гүнзгийрч чадаагүй байсаар, манай оюутан сэхээтэн чухам хэдийг нь эзэмшиж байх, манай монгол хэлний аспирант ба доктор чухам хэдийг нь эзэмшиж байх, малчид чухам хэдийг нь эзэмшиж байх, манай албан хэлний ажилтад (багш, нэвтрүүлэгч, хэл бичгийн ажилтан, боловсон хүчин) чухам хэдийг нь эзэмшиж байх, манай зохиолчид чухам хэдийг нь хэрэглэж байх, хүүхэд идэрчүүд ба настайчуулын үгээ мэдэх хэвцээ ямархан зөрөө ба жам ёстой байх, нэг хүний үгийн сангаа эзэмшсэн байдал нь нас жил хийгээд орчин тойрны хувирлын дагуу бас ямар хувирал гарч байх гэх мэтийн асуудлуудыг бүртгэн тодруулах явдал монгол хэл шинжлэлийг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд ба монгол хэлний заан сургах яс чанарыг дээшлүүлэхэд, үндэстний үг хэл үсэг бичгийг үнэнхүү цэцэглүүлэн хөгжүүлэхэд маш чухал ач холбогдолтой асуудал болох юм.

Б. Ринчен гуай тус зохиолдоо "...үгийн зүйлийг бүдүүвчилбэл нэг буман үг бардаагаар буй гэж болно. Бум гэж арван түм буюу өөрөөр өгүүлбэл зуун мянган үг аж" гэжээ. Энэ үгнээс үзэхэд уул тоо бол бүдүүвч барагцаалал болохоос биш нарийн оновчтой бүртгэл биш гэдэг нь тодорхой байна. Юу ч гэсэн хэвлэгдсэн толинуудын хэдэн түмэн үгийн дээр толь бичигт хараахан зурвас болж ороогүй ч ард түмний амьд хэл ярианд байдаг үлэмж баялаг хэлц үгээ нэмбэл манай монгол хэлний үгийн сан Б. Ринчен гуайн хэлсэн арван түмийн тоонд ойртох нь тодорхой хэрэг болох юм.

Хэл шинжлэлд хэлц хичнээн олон бол тэр хэл төчнөөн баян байдаг гэж үздэг учиртай. Ер нь аливаа хэлэнд хэлц үг байдаг боловч хэл хэлэн дэх хэлц үгийн тоо харьцангуйгаар олон цөөний ялгаатай байдаг. Монгол хэл бол хэлц үгээр баян хэлний нэгэнд зүй ёсоор орно. Гагцхүү шинжлэх ухааны боловсронгуй арга зүйн үүднээс тал бүрээс нь нарийвчлан судалж, мартагдаж байгааг нь тэмдэглэж, гээгдэж байгааг нь цуглуулан үгийн сангаа бүртгэх явдал хойшлуулшгүй чухал зорилтын нэг болон манай өмнө тавигдаж байна.

Хэл бол нийгмийн үзэгдэл болохоор байнга хөгжиж байдаг. Гэвч хэл нь зогсоо жолоогүй хувирч байдаг биш, харин заавал хуучнаа хадгалан, шинийг хуримтлуулж, хадгалан хувьсах замаар хөгждөг жамтай. Монгол хэл ч заавал энэ замаар хөгжих хэрэгтэй бөгөөд гагцхүү ингэмээжин л сая эрүүлээр хөгжиж чадна. Монгол хэлний үгийн сангийн системийн чухал нэгэн онцлог бол нэг язгуур үгнээс олон төрөл үг үржиж гардаг явдал болно.

Монгол хэлний ингэж үржиж гарсан үгс нь дан төрөл үг ба хоршоо төрөл үг гэх хоёр зүйлд хуваагддаг. "Нүд" гэдэг үгээр жишээлэхэд, "нүдлэх, нүдлэгдэх, нүдэрхэх" гэх мэтийн дан төрлийн үгсийг үржүүлж гаргагдаар барахгүй, "нүд алдах, нүд эрийх, нүд эрийлгэх, нүд эрээлжих, нүд эргүүлэх, нүд өргөх, нүд ирмэх, нүд орох, нүд оруулах, нүд ухах, нүд унагах, нүд орхих, нүд улайх, нүд урих, нүд өөхлөх, нүд өгөх, нүд үзэх, нүд үзэгдэх, нүд үзүүрлэх, нүд нээх, нүд нь орой дээрээ гарах, нүд нь улаанаар эргэх, нүд нь бөөстөх, нүд бэлчээх, нүд болох, нүд гаргах, нүд хагархай, нүд халтирах, нүд хадах, нүд хатгах, нүд хаях, нүд харайх, нүд харлах, нүд хариулах, нүд харвах, нүд хорхойтох, нүд хорсох, нүд хужирлах, нүд хөмсөг хөдөлгөх, нүд хөмсөг гүйлгэх, нүд хөших, нүд гарах, нүд гүйлгэх, нүд мадгүй, нүд суух, нүд шүд болох, нүд тайлах, нүд тавих, нүд татах, нүд таргалах, нүд тулах, нүд төөрөх, нүд дарах, нүд цавчих, нүд чих болох, нүд зарах, нүдийг нь олох, нүдийг нь бүлтийлгэх, нүдийг нь зааж өгөх, нүднээс гал гарах, нүдний хор гаргах, нүдний хорхой гаргах, нүдэндээ хавчихгүй, нүдэнд орсон хог шүдэнд орсон мах, нүдэнд хуруу хийх, нүдэнд шороо хийх" гэх мэтийн хоршоо төрөл үгсийг ч үүсгэдэг. Бүтцийн хувьд үг нэмж хасч болдоггүй тогтвор чанартай байж, утга зүйн хувьд дан нэгжээр хэрэглэгдэж бүхэл цогцоор илэрдэг ба хэлний зүйн талаар ч бүхэл бүтэн нэг цогцоор явж өгүүлбэрт нэгэн гишүүн болдог эдгээр хэлц нь илтгэх хүчин чадлын хувьд түүнтэй ижил утгатай дан үг ба чөлөөт холбоо үгнээс нэн их байж, хэл ярианд хурц оновчтой, амьд дүрслэг, энгийн ойлгомжтой, яруу тод, товч хураангуй зэрэг найруулгын чанар чадал ба үндэстний онцлог оруулж чаддаг болохоор сэтгэлд хоногших талаар онцлогтой байдаг.

Иймээс монгол хэлц бол өвөг дээдсийн маань бидэнд үлдээж өгсөн их өвүүдийн нэг мөнөөр зогсохгүй хүн төрөлхтөний соёлын санд монголын ард түмний нэмэрлэсэн эрхэм чухал ховор үнэт соёлын өвүүдийн нэг мөн. Хэлний судлалын чухал агуулгын нэг нь үгийн сангийн судлал байдаг бол, үгийн сангийн судлалын чухал агуулгын нэг нь хэлц судлал мөн. Хэлц үгээр үлэмж баян байдаг монгол хэлний үгийн сангийн энэхүү чухал онцлог нь толь бичигт тусгалаа олбол зохино. Гэтэл хэвлэгдэж өнгөрсөн толинууд ба ойрын жилүүдэд найруулагдсан толь бичгээс үзэхэд энэ талаар гүнзгийрээгүй шиг санагдана. Толь бичигт "хормой" гэдэг үг байхаас биш түүнээс үржиж гарч ирсэн хоршоо төрөл үг "хормой хийсгэх, хормой хиртэх, хормойд нь хий орох, хормойд шургах" гэх мэтийн үг байдаггүй. Энэ явдал бол үгийн баялгаа омтгойлж, хэлээ ядууруулж байгаагийн чухал нэгэн шалтгаан болно гэж би боддог. Толь бичигт байдаг үгс нь аль ч тольд цөм байдаг. Байхгүй үгс нь аль ч толиос олддоггүй гэж нийгэм дээр зарим хүмүүсийн ярьдаг нь буруу биш. Үүнийг монгол хэлний үгийн сангийн судалгаа гүнзгийрч чадаагүйн нэг илрэл гэж үзэлтэй. Манай залуу нөхөд, ялангуяа хотод өссөн залуучуудын дотор монгол үгээ сайн суръя гэж зориг шуудаж байдаг хүмүүс нэлээд харагддаг. Гэтэл монгол үгээ сурч мэдэх талд гарын авлага болмоор зүйл дутагдаж байгаа явдалд манай хэл бичгийн ба ном хэвлэлийн ажилтад хариуцлага үүрэх ёстой.

Миний бие мянга есөн зуун далай долоон оноос мянга есөн зуун наян зургаан оны арван жилийн хугацаанд ажлын хэрэгцээнээс болж, монгол хэлний тулгуур бичиг, сонгодог зохиол болон монгол хэлээр зохиогдсон роман, тууж, өгүүллэг, найруулал, кино жүжиг, дуу шүлэгтэй танилцаж, манай зохиолчдын хэлц үгээ хэрэглэж байгаа байдлыг анх алхам ажигласны дүнд их төлөв хоёр зүйлийн байдлыг олж харсан байна. Нэгд, он жилийн нэмэгдэх дарааллаар хэлц үгийн хэрэглэгдэх давтамж олноор буурч байна. Тулгуур бичиг, сонгодог зохиол болон эртний орчуулгын зохиолд хэлц үг нэлээд олон харагдана.

Тавиад оны зохиолд жараад оны зохиолоос илүү харагдана. Далаад он буюу наяд онд хэвлэгдсэн ном зохиол дахь хэлц үгийн давтамж жараад оноо ч хүрэхгүй болсон байна. Нэгэн ахмад зохиолчийн чөлөөлөх дайны үеийн зохиол ба "соёлын хувьсгал"-ын өмнөх үеийн зохиолыг нь одоогийн зохиолтой нь харьцуулж үзсэнд хэл хэллэгийн хувьд бараг хоёр хүний

зохиол гэмээр ялгаатай болж хойнох нь өмнөхөө хүрэхгүй болсон байдал илхэн харагдана. **Хоёрт**, зохиолчдын насны дарааллаар хэлц үгийн хэрэглэгдэх давтамж улмаар багасч байна. Адилхан цаг үед хэвлэгдсэн хоёр хүний зохиолыг харьцуулахад залуу зохиогчийн зохиолын хэл хэллэг нь ахмад зохиогчийн хэл хэллэгийг хүрэхгүй байдал харагдана.

Бүрэн бус бүртгэлээс үзэхэд "ам" гэдэг үгнээс үржих хэлц үг хоёр зуу шахам байдаг (өвөрмөц хэлц ба хэвшмэл хэлц, өөрөөр хэлбэл үгийн бүтэцтэй хэлц ба өгүүлбэрийн бүтэцтэй хэлц цөм багтана). Их сургуулийн монгол хэл утга зохиолын салбарын оюутад эх хэлний үгийн сангаа хэр зэрэг эзэмшиж байгааг ойлгох зорилгоор миний бие мянга есөн зуун наян дөрөвдүгээр онд нэг удаагийн дөхөм байцаалт хийж "ам"-аас үржих хэлц үгийг асуусанд их сургуулийн монгол хэлний салбарын дөчөөд хүнтэй нэг анги сурагчдын дотроос дээр зах нь арван дөрвийг л мэдэж байв. "Нүд" гэдэг үгнээс үржих хэлц үгийг бичүүлсэнд "бүлтгэр нүд, анигар нүд, солигор нүд, сохор нүд" гэж гүйцэтгэсэн хүн ч гарсан байв. "

Монгол хэл бичиг" сэтгүүлийн мянга есөн зуун наян зургаан оны наймдугаар хугацаанд нийтэлсэн "монгол хэл хэрэглээний байдалд хийсэн бага байцаалт" гэдэг өгүүллгийг бичсэн Баруун Хойтын Үндэстний дээд сургуулийн Хосмэнгэ, Надмид хоёр багшийн байцаалтаас үзсэн ч манай залуу оюутад эх хэлний үгийн сангаа хэр зэрэг эзэмшиж байгааг харж болно.

Одоо манай зарим залуучууд үгийн сангийн дадлагыг олтгойлоод, эртний юм оролдохыг хөөцөлдөх хандаштай болж байна. Миний үзэхээр, эртний юм оролдоход үгийн сангийн дадлага боловсрол нэн чухал шаардагдана. "Монголын нууц товчоо"-ны судлалын хамгийн үндсэн зүйл нь үгийн утгыг тайлбарлах явдал болно. Үгийн утгад навтарга гэдэг явдал залуу хүнд байтугай нэг ахмад эрдэмтний хувьд авч хэмээсэн ч тийм хялбар явдал биш байна. Өвөр Монголын ардын хэвлэлийн хорооноос хэвлүүлсэн

"Ойрад цааз"-ын 253-р нүүрт "хулгайч хүнийг тавь цохиод нэг сар хонгор азарга унуул" гэсэн үг байдаг. Хонгор азарга гэдэг нь урьдын цагт гэмтэн хэрэгтнийг агтлан хадгалах хэрэгслийг заадаг хэлц үг юм. Харгуулан тайлбарлагч энэ үгийг "хонгор азарга хэмээгч эмнэг азаргыг хэлж буй. Гэтэл зарим материалд зайдан азарга гэж тайлбарлаж байна. Юу боловч тавь цохисны дээр нэг сар эмнэг азарга буюу зайдан азарга унуулан яллах нь шогтой бөгөөд халтай ажил байна" гэж тайлбарласан байдаг.

Нэг зохиолчид авч хэлбэл зохиол бүтээлийнх нь амь нас, ардач чанар зэрэг нь зохиолчийн эх хэлний үгийн сангийн дадлага боловсролын хэр хэмтэй шууд холбогддог. Д. Нацагдорж, Ц. Дамдинсүрэн, Н. Сайнцогт нарын шүлгийг хөдөөгийн малчдад уншиж өгөхөд бараг бүр ойлгоцгоодог. Гэтэл одоо манай зарим залуу зохиогчийн бичсэн зохиол нь оньсого таавар шиг болчихоод хүн үзээд ойлгоход хүчиртэй болж байна. Миний үзэхээр энэ бол ард түмний хэл хэллэгийг суралцсанаар хүрэлцэхгүй. Эх хэлний дадлага боловсрол ба үгийн сангаа эзэмшсэн хэр хэмжээ доор байхаас болсон үзэгдэл болно.

Нэг орчуулагчийн хувьд авч хэлбэл, эх хэлний үгийн сангийн дадлага боловсролын хэр хэм нь орчуулагчийнх нь яс чанарыг шууд нөлөөлдөг. Монгол үгээ сайн мэддэг орчуулагч лав "даага"-ыг "хоёр настай морь", "бяруу"-г "хоёр настай үхэр", "хос"-ыг "асган гэдэс" гэж орчуулахгүй байхаа. Монгол хэлний өгүүлбэрийн хэвд тодотгол нь жинхэнэ нэрийн дээр нь орж тодотгогддог ёс хийгээд үгийн санд байдаг оёдлын машин, суудлын машин гэх мэтийн үгсээ сайн мэдэж байдаг орчуулагч "хүн машин"-ыг лав "машин хүн" гэж орчуулахааргүй, өгүүлбэрийн хэмд үйлдүүлэх хэв ба үйлдэх хэв зэрэгцэж болохгүй ёс ба үгийн сан дахь "сурган хүмүүжүүлэх ухаан" гэдэг үгийг сайн мэддэг орчуулагч лавтайяа "сурган хүмүүжлийн танхим" гэсэн нэр нь хүмүүст, сургах нь багшийн ажил, хүмүүжих нь сурагчийн ажил, энэ хоёр ажлыг хамтад нь ухдаг байгууллага юм байна гэсэн буруу ойлголт өгдөг болохоор оновчтой биш гэснийг мэднэ.

Үгийн сан дахь "хөдөө аж ахуй" гэдэг нэрийг мэддэг орчуулагч, мал аж ахуйн товчоо, тариалангийн товчоо, ус ашиглалтын товчоо, ой шугуйн товчоо зэргийг нийтэд нь хамаардаг байгууллагыг "тариалангийн зөвлөл" болгон шууд орчуулсан нь буруу болохыг мэднэ. Орчуулга ба нэр томъёо тогтоох ажил дээр илэрч байдаг аль олон асуудлын чухал нэг үндэс шалтгаан нь

бас л уул ажилд оролцож байгаа хүмүүсийн үгийн сангийн дадлага боловсролтой холбогдолтой болох нь маргашгүй тодорхой явдал болно.

Утга зохиолын хэлийг улам боловсронгуй болгоход сонин сэтгүүл, ном хэвлэл, радио телевиз, кино жүжгийн хэл хэллэг загвар үйлдэл гаргадаг бөгөөд энэ зорилтын хэрэгжихэд зохиолч, сэтгүүлч, соёл урлагийн ажилтад болон албан байгууллагын кадрчууд чухал үүрэг хүлээдэг. Манай сонин сэтгүүлийн хэл бохирдож байгаа тухай хүмүүс хааяа хэлэлцдэг. Энэ тухай зарим нөхөд сонин сэтгүүл дээр ч жишээ татаж өнгөрчээ. Миний үзэхээр иймэрхүү асуудлын үндэс сурвалж нь бас л үгийн сангийн боловсролын хэр хэмтэй холбогдоно. Манай зарим сонин дээр нийтэлсэн мэдээллийн "х х газрын малчид үхэр хонины баасаар шатаалга хийж байдаг" гэсэн өгүүлбэрээр үзсэн ч энэ асуудлыг тодорхой харж болно. Түлш хийдэг үхэр хонины баасыг аргал хоргол гэдгийг малжих орны хэлэнд орсон хүүхэд бараг цөм мэднэ. Энэ мэдээллийг бичсэн нөхөрт үгийн сангийн энэхэн дадлага байсан бол ийм өгүүлбэр найруулахгүй нь лавтай гэж би бодно.

Дуудлагын самуурлын үндсэн шалтгаан бас ч үгийн сангийн боловсролд холбогдоно. Эх хэлний үгийн сангаа сайн эзэмшсэн нэвтрүүлэгч "сэмжин" үүлийг "самжин" үүл, "мэс" заслыг "мас" засал, уулын "бэл"-ийг "бал", "мэрийн" чармайхыг "марайн" чармайх, "бээ" үгийг "бэх" үг гэж нэвтрүүлэхээргүй. "Олом" бол усны гатлах газар, "улам" бол нэн гэсэн утга, "содлох" бол содыг нь сонгох, "судлах" бол хянаж боловсруулах, "булах" бол үүрмэг юмаар бүтээж дарах, "болох" нь "бол-" гэдэг үгийн ирээдүй цаг, "бодох" нь сэтгэх, санах, "будах" нь будаг түрхэх гэсэн утгатай гэдгийг мэддэг багш яасан ч олом илүү, нягталж содлох, газар болох, бөс бодох гэж сурагчиддаа буруу заахааргүй.

Хэлний бохирдлын талаарх аль олон үзэгдлүүдийн чухал нэг шалтгаан нь үгийн сангийн боловсролтой холбоотой, монгол хэлний үгийн сангийн судлал онолын хувьд тодорхой болж чадаагүй, эзэлбэл зохих байраа олоогүй, судалгааны хөгжилт тэнцүүрээ алдсан явдалтай холбоотой гэж бодно. Үгийн сан бол эх хэлээ буюу уул хэлийг мэдье суръя гэсэн хүн бүхний заавал зайлшгүй сурах хэрэгтэй эрдэм мөн. Үгийн сангаа мөхөс мэдсэнээс болж манай судалгаа, найруулга, орчуулга, нэвтрүүлэг, хичээллэг зэрэгт дутагдалтай зүйл үргэлж харагддаг. Үгийн сангаа сайн мэдсэнээс болж манай бичиг зохиол найруулах, орчуулах, зөв яруу унших, нэр томъёо боловсруулах цаашилбал бүхий л үндэстнийхээ соёл шинжлэх ухааныг хөгжүүлэх зэрэгт хүчин чадал бүрдэж, хүсэл зорил биелдэг.

Нэг үндэстний хэлний хөгжилд албан хэлний үзүүлэх нөлөө маш их байдаг. Албан хэл нь хэлний хөгжлийг сайнаар нөлөөлөхгүй бол заавал муугаар нөлөөлдөг. Тус болохгүйд тушаа болохгүй явдал байдаггүй. Иймээс манай албан хэлний ажилтад ба залуу нөхөд юуны өмнө танилтаа нэгтгэж үүрэг хариуцлагаа тодорхой таних явдал нь манай хэлний хөгжилд бачим шаардлагатай ажил болоод байна гэж би боддог.

Манай улсын монгол хэл шинжлэлийн бодот байдалд чиглүүлэн энд би үгийн сангийн судлалын онол үйлдэлгийн асуудалд хэдэн зөвлөгөө дурдмаар байна.

1. Судлах байгууллага үгийн сангийн судлалыг гүнзгийрүүлж, судалгааны хөгжилтийн тэнцүүрээ алдсан байдлыг өөрчилбөл зохино. Чөлөөлөгдсөнөөс нааш манай монгол хэлний шинжилгээ маш түргэн хөгжив. Гэвч судалгааны хөгжилт тэнцүүргүй байна. Үгийн сангийн судлал хэл шинжлэлийн эл салбар дотор хамгийн буурай судлагдахуун болсоор ирсэн явдал бол нэгэн товойсон асуудал юм. Чөлөөлөгдсөнөөс нааших хагас зууны хугацаанд үгийн сангийн судлалын тусгай бүтээл үгүй.

Бүх улсын хэвцээнд монгол хэлний үгийн сан судлах тасаг гэж нэг ч байхгүй зэрэг нь монгол хэлний үгийн сангийн судлалын хэл шинжлэлд эзэлбэл зохих байраа эзэлж чадаагүй байхын тусгал мөн. Шинэ мэргэжлийн хувьсгал эхэлсэн өнөөдрийн цаг эриний хөгжилт хэл шинжлэлд нэн өндөр шаардлага тавих нь дамжиггүй. Юуны өмнө манай монгол хэлний судалгааны байдал тэнцүүргүй байгаа байдлыг өөрчилж, гүнзгийрээгүй зүйлийг гүнзгийрүүлж, хөндөөгүй зүйлийг хөндөхийг шаардаж байна.

Хэрэглээ судлал ба түгээмэлжүүлэх ажлыг чангатгаж, хэлний эрдэмтдийн судалгааг олон түмний дунд дэлгэрүүлж, хэлний хөгжилтийг жолоодуулан, хэл шинжлэлийн нийгэмч үйлдлийг бадруулахыг шаардаж байна. Манай улсын монгол хэл шинжлэлийг шинэ мэргэжлийн хувьсгал ба өөрчлөлт нээлтийн шаардлагад үнэнхүү нийцүүлбэ гэвэл, манай хэлний тухай танилт ба судалгаагаа шинэчлэх хэрэгтэй байна.

Онолын талаар гүнзгий судалж сүвэгчлэх хэрэгтэйгээр барахгүй, хэлний ажилтад танилтаа нэгтгэж, олон түмний хэлний мэдлэгийн талаарх танилтыг нийдэм дээшлүүлэх нь нэн чухал болж байна. Одоохонд монгол хэл бичгийн эгнээнд оршиж байгаа хэл зүйг хүндэтгээд үгийн санг хөнгөвчлөх, бичгийг хүндэтгээд яриаг хөнгөвчлөх, онолыг хүндэтгээд үйлдэлгийг хөнгөвчлөх үзэлт, арга ба онол үйлдэлгэ авцалдахгүй. Судалгаа хэрэглээ уялдахгүй. Хичээл хүмүүжил нь нийгмийн практикт нийлэхгүй байх зэрэг үзэгдэл нь хүмүүсийн санаа сэтгэлийг үймрүүлж, хэл шинжлэлийн нийгэмч үйлдэл ба монгол хэлний хөгжилтийн ирээдүй зэргийг зохих хэмжээгээр нөлөөлж байх болохоор эдгээр үзэгдлийг эрхбиш өөрчлөх чухалтай болоод байна.

Хэл шинжлэл бол бодот хэрэглээний чанараар туйлын чанга шинжлэх ухаан бөгөөд нийгмийн аль олон цар хүрээ, шинжлэл судлалын аль олон төрөл салбартай нягт холбогддог билээ. Ийм учраас онолын хэл шинжлэл яриангүй чухал боловч, хэрэглээний хэл шинжлэлийг яасан ч олтгойлж болохгүй. Манай улсын монгол хэл шинжлэлийн одоох байдлаас үзвэл, хэрэглээний хэл шинжлэлийг ихээр чангатгавал зохино. Ийм үзэл санаа манд тун хэрэгтэй болоод байна. Бид ингэмээжин, манай хэл шинжлэл амьдрах хүчнээр бялхаж, манай үйлс улам өөдлөн дэгжирч, манай хэл бичгийн ажилтад цаг эринд нийцсэн хувь нэмрээ үзүүлж чадна. Уламжлалт хэл шинжлэлд бичгийн хэлийг илүү анхаарч, ярианы хэлийг хөнгөвчилдөг тал байдаг.

Хэл шинжлэлийг ийм зам мөрөөр хөтөлж ирсэн үзэл санааг өөрчлөх чухалтай гэж би үзнэ. Ярианы хэл бол бичгийн хэлний суурь бөгөөд хэрэглээний давтамж нь бичгийн хэлнээс хол илүү байдаг болохоор ярианы хэлийг судалмаажин сая хэл шинжлэлд хэрэгсэх баялаг хэрэглэгдэхүүн хангагдаж, бичгийн хэлийг нэн сайн судлах боломжтой болдог.

2. Үгийн сангийн хүмүүжүүллийг үндэстний сурган хүмүүжүүллийн системд нэвтрүүлэх чухалтай. "Үй түмэн ард олон үндэстнийхээ хэлийг хэрэглэмээжин соёл, улс төр ба аж ахуйн талаар асар их дэвшиж чадна" гэж Сталин хэлсэн байдаг. Сурган хүмүүжүүллийн үйлдэлгийг зохих утга санааны үүднээс авч хэлбэл, тэр нь хүмүүст үг хэлийг сайн сайхан сургаж эзэмшүүлэх явдал болохоор барахгүй, мэдэгдсэн мэдээ зангийг хураангуйлан нэгтгэж, мэдлэг туршлага болгон хувиргаад, бусдад дамжуулах өвөрмөц явц мөн. Үндэстний сурган хүмүүжүүллийн үйлдэлгийг зохих утга санааны үүднээс авч хэлбэл, эх хэлээ залгамж хойч үедээ дорвитой сайн сурган эзэмшүүлэх явдал мөн.

Энд бусад төрлийн хичээлийг хэлэхгүй, зөвхөн хэл бичгийн хичээлийг авч хэлэхэд, үгийн санг эзэмшүүлэх явдал бага, дунд сургуулийн монгол хэл бичгийн хичээлийн нэгэн голдлого байвал зохино. Сурагчдад эх хэлнийхээ үгийн санг бага сургуульд хэдий эзэмших, дунд сургуульд хэдий эзэмших, их сургуульд хэдий эзэмших талаар дурдсан баримжаа, тодорхой программ байвал зохино.

Орчин үеийн их сургуульд сурагч элсэх шалгалт нь үнэндээ хэл зүйн л шалгалт төдийгөөс биш, үгийн сангийн шалгалт биш гэж хэлэхэд болно. Яг ийм учраас их сургуулийн монгол хэл утга зохиолын салбарын оюутад буюу монгол хэлний аспирант болон докторын үгийн сангийн мэдлэгт наад захын шаардлага дутагдаж байна. Үүнд дүнд хэлний эрдэмтдийн үгийн сан нь малчдыг хүрэхгүй, сургуульд ороогүй хүүхдийн хэл нь сургуульд орсон хүүхдийн хэлнээс цэвэр байдаг сөөрөг үзэгдэл зөндөө харагддаг болжээ.

Хөгжсөн үндэстний хэл бичгийн сурган хүмүүжүүллийг үзэхэд эх хэлний үгийн сангаа эзэмшүүлэх явдлаар чухал агуулга болгосоор иржээ. Өнгөрсөнд монгол хэл бичиг заахад толь бичгээр сурах бичиг болгож байсан ба зүйр цэцэн үг цээжлүүлж байсан зэрэг нь манай урьдах

хүмүүсийн үгийн сангаа эзэмшихийн чухал чанарыг зөв ойлгож, үгийн сангаа онолын хувьд ба үйлдэлгийн хувьд хүндэтгэж байсны гэрч мөн гэж хэлж болно. Хятад үндэстнийхэн гэрийн сургуулийн сурагчиддаа "Сан зи жин", "Мин сиян жи" бичгийг цээжлүүлдэг байсан нь тэдгээр номууд нь тухайн цаг үедээ утга зүйн хувьд ба орчуулгын хувьд цөм уул уул үндэстний хэлний боловсролд хэв загвар үлгэр дууриал болмоор охь сонгодог зүйл байсанд оршино. Яг ийм учраас тухайн үеийн гэрийн сургуулиас төгсөгсдийн хэлний боловсролын түвшин нэлээд өндөр байжээ гэж би боддог.

"Монгол хэл бичиг" сэтгүүлийн мянга есөн зуун наян зургадугаар оны тавдугаар хугацаанд нийтэлсэн "судлууштай асуудал" гэсэн өгүүллээс бид анх зэргийн дунд сургуулийн монгол хэл бичгийн хичээлийн дэвтрийн агуулга ямар хувиралттай болж байгааг ойлгож болно. Тавиад оны эхний үеийн таван дэвтрийн 90 хичээлд орчуулсан зохиол 30 орж, 33% орчмыг эзэлж байсан бол наяд он болоход зургаан дэвтрийн 151 хичээлд орчуулсан зохиол 93 орж, 61.5%-ийг эзлэх болжээ. Үүний эсрэгээр хятад анх зэргийн дунд сургуулийн хэл бичгийн хичээлийн дэвтрийн агуулгыг үзвэл таван дэвтрийн 138 хичээлд орчуулсан зохиол 12 орж, 8.6%-ийг л эзэлж байна.

Хэлний дадлага боловсролын хувьд авч үзвэл, Хэшингэгийн үеийн "анхан сурах улсын утга" манай тавиад оны хичээлийн дэвтрээс сайн, тавиад оны хичээлийн дэвтэр наяд оны хичээлийн дэвтрээс сайн гэж хэлж болмоор. Яг ийм учраас малжих орны хүүхэд сургуульд орохоосоо өмнө "бид сайхан шинэлсэн", "энэ миний аав", "тааж үз л дээ" гэх мэтээр хэлдэг байснаа сургуульд орсны хойноо "бид цагаан сарыг сайхан өнгөрүүлэв", "энэ бол даруй миний аав", "тархиа хөдөлгөж үз дээ" гэх болчихдог байна.

Иймээс бид залгамж хойч үеийхэндээ үгийн сан эзэмшүүлэх явдлыг хүүхдийн цэцэрлэгээс эхэлж бага, дунд сургуулийн монгол хэл бичгийн хичээлийн голдлого болгон ухвал зохих бөгөөд хичээл нь заавал эх хэлээр бичигдсэн хэл найруулга сайтар зохиол байвал зохино. Үүнд манай монгол ардын аман зохиолын төрөл зүйл нь манай үндэстний ард түмний залгамж хойч үеэ сурган хүмүүжүүлэх арга туршлагын сонгодог хэлбэр болно. Жишээлбэл: сая хэлэнд орж байх хүүхдийн хэлний цулчрааг тайлахын төлөө нарийн дүрэм журмаар зохиогдсон хэл боловсруулах үгийг цээжлэх, үг аялгыг нь нэлээд оновчтой авиалуулсан суурин дээр үгийн санг нь цаашид баяжуулах зорилгоор уран сайхан хэлэлгэд дадлагажуулах, зүйр цэцэн үг цээжлүүлэх зэрэг бол манай үндэстний ард түмний олон зуун жилд боловсруулж ирсэн ардын сурган хүмүүжүүлэх ухааны бүтэмжтэй арга туршлаганууд болно.

Монгол хэлний бүтэц чухам яаж эхэлж бүрэлдсэн тухай бид хүүхдийн хэлэнд орж байх байдлаас ажиглаж сүвэгчилбэл, монгол хэл бараг үгээр суурь болгон бүтсэн байж магад гэж үзэж болно. Учир нь монгол хүүхэд эхлээд авиагаар биш, нэн ч өгүүлбэрээр биш харин голдуу үгээр хэлд ордог байна.

Монгол хэлний зүйр цэцэн үг нь манай ард түмний улс төрийн үзэл, зан суртахуун, хэв ёсны хэм хэмжээг илтгэж, нийгэм түүхийн үзэгдлийг шинжлэн дүгнэсэн байдаг ба ямагт амьдралын үнэнийг хэлж хүнийг аж амьдралгад санаа сэхээ авуулан, сайныг дагаж, мууг жигшүүлэхэд сургадгаараа соён гийгүүлэх ач тустай юм.

"Зүйр цэцэн үг хийгээд хууч үгс ард түмний хөдөлмөрийн бүхий л амьдралын нийгэм, түүхийн туршлагыг дүр гарган хэлбэржүүлж өгдөг" гэж М. Горький хэлсэн байдаг. Зүйр цэцэн үгийн гадна орхигдсон амьдралын аль нэгэн үзэгдэл байхгүй гэхэд болох бөгөөд хамаг орчлонгоос өдөр тутмын ажил явдлын аар саар зүйлс ч цөм багтаагдсан байдгаараа амьдралын нэвтэрхий толь гэхэд болох юм. Манай хэлдэг "зүйргүй үг үгүй, зүйдэлгүй дээл үгүй" гэдэг нь яг энэ утга учрыг хэлж байгаа юм.

Зүйр цэцэн үг нь түүний утга зүйн хувьд ба өгүүлбэрийн найруулгын хувьд цөм эх хэлээ сурахад үлгэр жишээ болохуйц охь сонгодог зүйл болох юм. Бид монгол ардын аман зохиолын томоохон төрөл зүйл болох зүйр цэцэн үг ба түүнийг ардын сурган хүмүүжүүлэх ухаанд бүтээлчээр ашиглаж ирсэн уламжлалт арга туршлагыг хэл шинжлэлийн үүднээс тусгайлан

судлахын хамт үндэстний сурган хүмүүжүүлэлдээ загвар болгон үндэстний сурган хүмүүжүүллийн яс чанарыг баттай дээшлүүлэх ба манай далай баян үгийн сангаа залгамжлан авч хойч үеэ сурган хүмүүжүүлж манай үгийн сангийн энэхүү үнэт өвөө үв үнэнхүү өвөг дээдийн маань өв, өнөөгийн бидний ч өв, өсгий залгаж ирэх өсвөр үеийнхэндээ ч өнөд өв болгон өвлүүлэх явдал туйлын бачим чухал түүхэн үүрэг болон бидний өмнө тавигдаж байгааг заавал зөв тод таних хэрэгтэй байна.

3. Үгийн сангийн ядуурлыг хориглох олон зүйлийн идэвхтэй арга хэмжээ авбал зохино. Бидэнд үгийн сангийн дадлага боловсролд чиглэгдсэн олон зүйлийн идэвхтэй бөгөөд шийдэмгий шалмаг арга барил бачим шаардагдаж байна. Жишээлбэл, албан хэлний ажилтдад үгийн сангийн өндөр шаардлага тодорхой баримжаа тогтоох ба олон хэлбэрийн боловсролын анги эрхлэх, хүүхдийн цэцэрлэгийн багш нар болон бага, дунд, дээд сургуулийн монгол хэлний багш нарын үгийн сангаа эзэмшсэн хэр хэмийг шалгах уралдааныг тогтмол хугацаагаар зохион байгуулж шалгарсныг шагнаж хөхүүлэх, дээд сургуульд шалгагсад, ажилд элсэгдэгсэд, ялангуяа албан хэлний ажилд элсүүлэгчийг үгийн сангийн дадлага боловсролын хэр хэмийн шалгалт хүлээлгэх, хэл бичгийн байгууллага, радио телевиз, сонин сэтгүүл хүүхдийн цэцэрлэг, сургуулиудад зүйр цэцэн үгийн уралдаан зохион байгуулах, сонин сэтгүүл, телевизийнхэн хэлний бохирдолд чиглүүлсэн хэлний шүүмж өрнүүлэх мэтийн ажиллагаа нь үгийн сангийн ядуурлыг хориглоход цөм зохих үйлдэл үзүүлж болно.

Хэлний ядуурал ба хэлний бохирдлын асуудал дээр бид хэнд ч гомдсоны хэрэггүй. Хэнд ч найдсаны хэрэггүй. Танилтаа нэгтгэж, өөрийн хүчиндээ итгэн, өөрийн хүчиндээ түшиглэж, зөв шаламгай арга авч, өөр өөрсдийнхөө хийж дийлдэг ажлаа үнэнхүү хийдэг л юм бол лав хэрэгжиж, далай баян үгийн сангаа залгамжлан авч уламжлан үлдээж лав чадна гэдэгт бат итгэж байна.

